




“ЭС ТИ БИ ЭС” ХХК-ИЙН СҮЛЖЭЭНИЙ ХЯНАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмаар “Эс Ти Би Эс” ХХК-ийн суурь, түгээх, хэрэглэгчийн сүлжээний хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах, гэмтэл саатлаас урьдчилан сэргийлэх, гарсан гэмтэл саатлыг богино хугацаанд арилгахтай холбоотой асуудлыг зохицуулна.

Хоёр: Сүлжээний хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих

1. Сүлжээний хяналтыг ээлжийн операторууд хянана. Сүлжээний нэгдсэн программ нь 24/7 зарчимд тулгуурласан байна.
2. Ээлжнээс буусан оператор рапортын дэвтэрт Сүлжээний хяналтын явцыг тэмдэглэн дараагийн ээлжний операторт хүлээлгэн өгнө.
3. Оператор нь сүлжээ хэвийн боловч хэрэглэгч, харилцагч талаас дохио ирэхгүй байх, хүлээн авч чадахгүй болсон тохиолдолд хяналтын хуудсанд тэмдэглэж, хэрэглэгч, харилцагчид мэдэгдэх үүрэгтэй.
4. Хэрэглэгч харилцагч дохио хүлээн авахгүй байх, дамжуулалт хийж чадахгүй байгаа талаар мэдээлсэн нөхцөлд сүлжээний хэвийн үйл ажиллагааг Сүлжээний нэгдсэн программаар шалгаж, сүлжээ хэвийн бол нөгөө талдаа мэдэгдэнэ. Хэрэв сүлжээнд гэмтэл саатал гарсан бол инженер, техникчид сүлжээнд гарсан гэмтэл саатлын мэдээллийг дамжуулж, засварлуулах арга хэмжээ авч ажиллана.

Гурав: Сүлжээний гэмтэл саатлыг засварлах

1. Сүлжээнд гарсан гэмтэл саатлын дуудлага хүлээн авсан инженер, техникийн ажилтан хэрэглэгчийн сүлжээнд гарсан гэмтлийг ажлын 2 цагийн дотор засварлаж, хэвийн болгох үүрэгтэй.
2. Инженер техникийн ажилтан нь түгээх сүлжээнд гарсан гэмтэл саатлыг ажлын 4 цагийн дотор засварлаж, хэвийн болгох үүрэгтэй.
3. Инженер техникийн ажилтан нь суурь сүлжээнд гарсан гэмтэл саатлыг ажлын 8 цагийн дотор засварлаж, хэвийн болгох үүрэгтэй.
4. Суурь сүлжээнд гарсан гэмтэл нь холбооны худаг сувагчлал дахь сүлжээнд гарсан бол “Мэдээлэл, холбооны сүлжээ” ХХК-ийн шуурхай албатай холбогдож, АТС-ын хамрах хүрээг дурдан хийх ажил, ажиллах ажилтны мэдээллийг и-мэйлээр илгээж зохих зөвшөөрлийг авсны дараа ажлыг эхлүүлнэ. Засварын ажлыг яаралтай, богино хугацаанд хийж гүйцэтгэхэд ахлах инженер хяналт тавьж, ажлыг зохион байгуулж ажиллана.
5. Сүлжээний гэмтлыг арилгахад их хугацаа орох, ажил удааших шинжтэй бол нөөц сүлжээнд холбох ажлыг ажлын 6 цагийн дотор хийж гүйцэтгэсэн байх үүргийг Сүлжээ хариуцсан инженер хүлээнэ.
6. Сүлжээнд гарсан гэмтэл саатал нь сүлжээний төхөөрөмжөөс шалтгаалсан бол нөөцийн төхөөрөмжөөр сольж хэвийн болгох ажлыг Инженер техникийн ажилтан хийж гүйцэтгэнэ.
7. Гэмтэл саатал нь хэрэглэгч, харилцагч талын сүлжээний төхөөрөмжтэй холбоотой бол зохих заавар зөвлөгөөг өгч төхөөрөмжийг солиулах арга хэмжээг авна.

8. Сүлжээний гэмтэл саатлыг арилгах ажилтанд тухай бүр нь ХАБЭА-ны журамд заасны дагуу нөхцөл байдалд нь тохирсон зааварчилгааг өгч ажиллах үүргийг ХАБЭА хариуцсан мэргэжилтэн хариуцна.

Дөрөв: Сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах

1. Суурь, түгээх, хэрэглэгчийн сүлжээний хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Сүлжээ хариуцсан инженер хариуцна.
2. Сүлжээний төхөөрөмж, дамжуулах төхөөрөмж, түгээх төхөөрөмж, сүлжээний хяналтын программын хэвийн үйл ажиллагааг Head-End хариуцсан инженер хариуцна.
3. Сүлжээний хэвийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг операторууд хийнэ.
4. Суурь сүлжээнд жилд 1 удаа үзлэг шалгалт хийх үүргийг Сүлжээний инженер хүлээнэ. Уг ажлыг зохион байгуулахдаа “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн төлөвлөгөөт ажилтай уялдуулж ажиллана.
5. Түгээх сүлжээний хяналтыг улирал бүр бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, тухай бүр АКТ үйлдэн ажиллана.
6. Хэрэглэгчийн сүлжээний хяналтыг сар бүр тухайн хэрэглэгчтэй байгуулсан гэрээний дагуу хийнэ.
7. Сүлжээний төхөөрөмж, дамжуулах төхөөрөмж, түгээх төхөөрөмж, сүлжээний хяналтын программын хэвийн үйл ажиллагаанд 7 хоног бүр үзлэг шалгалт хийх бөгөөд тухай бүр АКТ үйлдэн ажиллана.
8. Үзлэг шалгалтын явцад төхөөрөмж хэвийн бус ажиллаж байвал нөөцийг төхөөрөмж авах, бэлэн байлгах ажлыг ажлыг яаралтай зохион байгуулж, Удирдлагын хурлаар хэлэлцүүлж шийдүүлнэ.
9. Сүлжээ, Сүлжээний төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх, бэлэн байлгах ажлыг Ерөнхий инженер хариуцна.

Тав: Хариуцлага

1. Энэхүү журмын хэрэгжилтэнд компанийн захирал хяналт тавьж ажиллана.
2. Ажилтнууд олон давтан гардаг гэмтэл, саатал, доголдлыг бууруулах, арилгах талаар бодит санал санаачлага гаргасан бол сайшааж, урамшуулна.
3. Журмаар зохицуулж буй харилцааг үл биелүүлсэн, хариуцлага алдсан ажилтанд Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу хариуцлага тооцно.